



Бие даан
суралцах ажлын
дэвтэр
ГАЗАРЗҮЙ
XI анги



.....
.....
.....
.....
.....



11 дүгээр ангийн Газар зүйн хичээлийн бие даан суралцах ажлын дэвтрийн өөрийн үнэлгээний зураглал

Бүлэг сэдэв	Дэд сэдэв	Ажлын хуудас	Даалгавар	Өөрийн үнэлгээ*		
				Багшаас дэмжлэг авах	Бие даан судлах, дахин гүйцэтгэх	Хангалттай сайн
Гео орон зайн дүрслэл	11.1. Газар зүйн зураг	1	1			
			2			
			3			
		2	1			
			2			
			3			
	11.2. Гео-орон зайн технологи	1	1			
			2			
			3			
		2	1			
			2			
			3			
Дэлхий бидний орон гэр	11.3. Хөгжлийн газар зүй	1	1			
			2			
			3			
			4			
			5			
		2	1			
			2			
			3			
			4			
			5			
	11.4. Даяаршил ба дангаарчлал	1	1			
			2			
3						
4						
Хүн ам ба суурьшил	11.5. Дэлхийн хүн амын тоо, өсөлт	1	1			
			2			
			3			
			4			
		2	1			
			2			
			3			
			4			
	11.6. Дэлхийн хүн амын нас, хүйсийн бүтэц	1	1			
			2			
		2	1			
			2			
			3			
			4			
			5			
			6			
			7			

*-Өөрийн үнэлгээний тохирох хэсэгт ✓ тэмдэг тавиарай.

Үргэлжлэл

Бүлэг сэдэв	Дэд сэдэв	Ажлын хуудас	Даалгавар	Өөрийн үнэлгээ*		
				Багшаас дэмжлэг авах	Бие даан судлах, дахин гүйцэтгэх	Хангалттай сайн
Хүн ам ба суурьшил	11.7. Дэлхийн хүн амын угсаатны бүтэц	1	1			
			2			
			3			
	11.8. Хүн амын байршилт, шилжилт	1	1			
			2			
			3			
	11.9. Хот, хөдөөгийн хүн ам, хотжилт	1	1			
			2			
			3			
			4			
		2	1			
			2			
3	1					
	2					
	3					

*-Өөрийн үнэлгээний тохирох хэсэгт ✓ тэмдэг тавиарай.

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ____ он ____ сар ____ өдөр ____ цаг


ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

11.1. Газар зүйн зураг

Даалгаврын товч тайлбар: Үзэгдэл, үйл явц бүхэн ялгаатай график, диаграммаар илэрхийлэгддэг. Ингэснээр тухайн үзэгдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг ялган харах боломжтой болно.

1. А хотын хүн амын тоон өөрчлөлтийг ашиглан өгөгдсөн зайд тохиромжтой график/диаграммыг зураглаж, тухайн график/диаграммыг сонгосон шалтгаанаа тайлбарлаарай.


Он	Хүн амын тоо
1940	45000
1950	75500
1960	121000
1970	156500
1980	194500
1990	232500
2000	300000
2010	375000
2020	450000
2030	525000



.....


2. Улс орнуудын хүн амын ажил эрхлэлтийн салбарын хүснэгтэн мэдээг ашиглан тойргон диаграмм байгуулаарай.

Улс	Анхдагч салбар, %	Хоёрдогч салбар, %	Гуравдагч салбар, %
Энэтхэг	60	12	28
Япон	5	25	70
Камерон	71	12	17



3. Хүснэгтэн мэдээллийг ашиглан гурвалжин диаграмм дээр А, Б, В улс орнуудын хүн амын ажил эрхлэлтийн бүтцийг тэмдэглээрэй.

Улс	Анхдагч салбар, %	Хоёрдогч салбар, %	Гуравдагч салбар, %
А	75	10	15
Б	50	30	20
В	40	25	35



Дууссан: ___ сар ___ өдөр ___ цаг

Өөрийн үнэлгээ: ___

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

11.1. Газар зүйн зураг

Даалгаарын товч тайлбар: Нийгэм эдийн засгийн судалгаа хийхдээ тохиромжтой аргыг сонгосноор зорьж буй үр дүндээ хүрэхэд хялбар болно. Жишээлбэл, ажиглалт хийхдээ хялбараар тэмдэглэл хөтлөх нь хугацаа хэмнэхээс гадна, боловсруулалт хийхэд хялбар байдаг.

1. Өөрийн амьдарч буй газар (гэрийнхээ эргэн тойрон), сургуулийн гадаах талбайд хүүхдүүд цагийг хэрхэн өнгөрүүлж буйг ажиглаж, дараах ажиглалтын хуудсанд тэмдэглээрэй. Тэмдэглэхдээ 1 хүүхэд бол I, 2 хүүхэд II, 4 хүүхэд тоглож байвал тус бүрд нь I буюу нийт III тэмдэглэх бөгөөд 5 хүүхэд бол III тэмдэглээрэй.

Сар: өдөр:	Гэрийн ойролцоох тоглоомын талбай				Сургуулийн гадаах талбайд тоглож буй тоглоомын төрөл			
	Сагсан бөмбөг	Хөл бөмбөг	Гулсуур, савлуур	Бусад:	Сагсан бөмбөг	Хөл бөмбөг	Гар бөмбөг	Бусад:
Эрэгтэй								
Эмэгтэй								

2. Ажиглалт хийхэд 1, 2, 3 гэж тоогоор тэмдэглэхийн оронд босоо зураасаар (I; III г.м.) тэмдэглэхийн давуу талыг тодорхойлоорой.

.....

3. Хүүхдүүд аль төрлийн тоглоомыг илүү их тоглож байна вэ? шалтгааныг нь тайлбарлаарай.

Гэрийн ойролцоо:

.....

Сургуулийн гадаах талбай:

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

11.2. Гео-орон зайн технологи

Даалгаарын товч тайлбар: Газарзүйн мэдээллийн систем гэдэг нь орон зай, цаг хугацаанаас хамаарсан аливаа байгаль нийгмийн үзэгдэл, үйл явцыг мэдээллийн технологи буюу компьютерын тусламжтайгаар боловсруулах зориулалт бүхий мэдээллийн систем юм. ГМС -ийн өгөгдөл нь давхарга хэлбэрээр хадгалагдаж, давхарга болгон тодорхой сэдвийн агууламжтай байдаг.

Цахим эх сурвалжид <https://eic.mn/geodata/> тулгуурлан дараах дасгалуудыг гүйцэтгээрэй.

1. Гео-мэдээллийн сангийн цахим мэдээллийг ашиглан, өгөгдсөн зайд тохирох мэдээллийг нөхөөрэй. Жишээг саарал хэсгээр харуулав.

Газрын зураг	Давхаргын тоо	Давхаргуудын нэршил
Засаг захиргааны зураг	6	1. Улсын хил 2. Аймгийн хил 3. Аймгийн төв 4. Сумын хил 5. Сумын төв 6. Эдийн засгийн бүс
Замын сүлжээний зураг		
Байгалийн бүс, бүслүүрийн зураг		

2. Ургамалжилтын зургийн давхарга тус бүрийг идэвхжүүлж, “ургамалжилтын ангилал”-давхаргын зургийг сонгож, “цөлийн бүс” – ийн тархалтыг дүрслээрэй.

.....

3. Засаг захиргааны зураг 6 давхарга бүхий зургуудаас бүрдэж байгаагийн шалтгааныг тайлбарлаарай.

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

11.2. Гео-орон зайн технологи

Даалгаврын товч тайлбар: Google Earth программыг гар утас, компьютер зэрэг төхөөрөмжийн тусламжтайгаар ашиглаж дадах нь өөрийн байгаа байршил, зорин очих газраа тодорхойлох, дөт замыг сонгон явах боломжийг зааж, чиглүүлдэг.

Google Earth программ ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

1. Мандалговь хотын байршлыг тодорхойлоорой (Сурах бичгийн хуудас: 18. Байршлыг хаягаар хайх хэсгийг даган гүйцэтгэх).

Өргөрөг:

Уртраг:

2. Дараах солбицолд орших объектыг нэрлээрэй. Х.Ө.43°35'05"; З.У.104°25'37"

.....

3. Улаанбаатар хотын "Баруун 4 зам"- аас "Номин Супермаркет – Зүүн 4 зам" хүртэл автомашинаар АНЗ, Их тойруу, Нарны замаар хэдий хугацаа зарцуулан, хэдэн км явахыг тодорхойлно уу.

Зам	Туулах зай	Зарцуулах хугацаа
АНЗ		
Их тойруу		
Нарны зам		

4. Мандалговь хотын газар ашиглалтын өөрчлөлтийг (2002 ба 2020 онуудыг харьцуулан) полигон үүсгэн зураглаарай (Сурах бичгийн хуудас: 19. Шугам болон полигон зураг хэсгийг даган гүйцэтгэх).

5. Мандалговь хотын газар ашиглалтын өөрчлөлтийг дүрслээрэй.

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ____ он ____ сар ____ өдөр ____ цаг

ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР


11.3. Хөгжлийн газар зүй

Даалгаарын товч тайлбар: Цалин орлого, эмнэлэгт ажиллаж буй эмчийн тоо, хүртээмж, дундаж наслалт зэрэг нь улс орнуудын хөгжилд хэрхэн нөлөөлж байдгийг ялган танина.

Хүснэгтэн болон зурган мэдээлэл ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй.

Улс	Нэг хүнд ногдох ДНБ, \$ https://statisticstimes.com	Их эмчийн тоо (10 000 ногдох), 2014-2019 https://www.who.int	ХХИ, 2020 http://hdr.undp.org/
АНУ	63400	26	0.932
БНХАУ	10400	20	0.761
Япон	40100	25	0.919
Энэтхэг	1960	9	0.645
Бразил	6700	23	0.765
Польш	15600	24	0.880
Норвеги	67000	49	0.957
Шинэ Зеланд	41000	34	0.931
Казахстан	8700	40	0.825
Танзани	1000	1	0.529
Монгол	3900	38	0.737
Намиб	4100	9	0.646

Дэлхийн улс орнуудыг эдийн засгийн хөгжил, байгалийн нөөц зэргээр нь газар зүйн зурагт ялган зурвал хойд тал бөмбөрцөгт хөгжингүй орнууд (Монгол, Хятад, Турк зэрэг цөөн улс орнуудыг эс тооцвол), харин өмнөд хэсэгт хөгжиж байгаа, нэг хүнд ногдох ДНБ доогуур орнууд (Сингапур, Австрали, Шинэ Зеланд зэрэг цөөн улс орнуудыг эс тооцвол) ялгарч зурагдана. Энэ ялгааг төсөөлөн гаргасан эрдэмтэн Брандтын нэрээр “Брандтын шугам” хэмээх нэр томъёо үүссэн аж.



1. Дараах улс орнуудаас аль нь хөгжиж буй улсад хамаарах вэ?

- A. Австри
- B. Дани
- C. Канад
- D. Монгол

2. Дотоодын нийт бүтээгдэхүүн гэж юу вэ?

.....

.....

.....

3. Хүснэгтэд өгөгдсөн улс орнуудын мэдээг ашиглан Брандтын шугамаас өмнө хэсэгт орших улсуудыг нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр нь ихээс багаруу нь жагсаагаарай.


.....

.....

.....

4. 10 000 хүнд ногдох их эмчийн мэдээг ашиглан хоосон зайд тохирох баганыг зураарай.

Их эмчийн тоо (10 000 ногдох), 2014-2019



5. 10 000 хүн тутамд ногдох их эмчийн тоо нэмэгдсэнээр ХХИ өсөх үү? Баримтад тулгуурлан шалтгаанаа тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ____ он ____ сар ____ өдөр ____ цаг

ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР

11.3. Хөгжлийн газар зүй

Даалгаарын товч тайлбар: Байгалийн нөөц, ажлын байрны хүртээмж, ДНБ-ий өсөлт зэрэг байгаль, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс нь улс орнуудын хөгжил хэрхэн нөлөөлж байдгийг судлан танина.

1. Доор өгөгдсөн утгуудыг ашиглан аалзан диаграммыг нөхөөрэй.

1) Ажлын байрны хүртээмж

4) ДНБ-ий өсөлт

7) Хөрсний элэгдэл

2) Алт, зэсийн нөөц

5) Тэгш хамрагдан суралцах боломж


8) Хууль хэрэгжилт

3) Аюулгүй энх тайван байдал

6) Усны бохирдол

9) Цалин, урамшуулал

10) Эрүүл мэндийн үйлчилгээ



Норвеги, БНХАУ, Нигер улсуудын тухай (сурах бичгийн 26, 27, 28 нүүр) Кейс шинжилгээг уншиж дараах асуултад хариулаарай.

2. Норвеги улсын дотоодын эрчим хүчний гол эх үүсвэрийг сонгоорой.

- A. Нүүрс
- B. Газрын тос
- C. Гол, тэнгисийн ус
- D. Газрын гүний энерги

3. Норвеги, Хятад, Нигер улсуудын газар зүйн байршлыг дүрсээрэй.

.....

.....

.....


.....

.....

.....

.....

4. Улс орны хөгжилд далайд гарцтай эсэх нь хэр их нөлөөтэй болохыг дараах шугаман хэмжээст тэмдэглэнэ үү (ямар ч нөлөөгүй гэж үзвэл “0”, маш их нөлөөтэй гэвэл “10”).



5. Өөрийн тэмдэглэсэн тоон хэмжээнд тулгуурлан жишээ ашиглан тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР

11.4. Даяаршил ба дангаарчлал

Даалгаарын товч тайлбар: Бид даяаршиж буйгаа хэрхэн мэдэх вэ? Нийгэм, эдийн засагт гарч буй өөрчлөлтийг ажиглан үүнд хариулах боломжтой.

- Даяаршил гэдэг тохирох утгыг сонгоно уу.
 - “Пепси” ундааны үйлдвэр Эрдэнэт хотод байгуулагдах
 - “Эрдэнэт” хивс компани салбараа Дархан хотод байгуулах
 - “Тоёото” машины үйлдвэр Японы Сайтама хотод үйл ажиллагаагаа явуулах
 - Энэтхэгийн “Тата” компани гангийн борлуулалтаа Дели хотод нэмэгдүүлэх

- Чөлөөт худалдаа гэдгийг тодорхойлно уу.

.....

.....

.....

- Дараах мэдээлэл нь даяаршлын ямар хэлбэрт хамаарах вэ?

Осло хотын зарим иргэд өглөөний цайндаа Боливт тариалсан кофе ууж, өдөр Кенийн тариалангийн талбайгаас хураасан гадил, Вьетнамаас ирсэн манго жимс идэж, BBC сувгийн мэдээ сонсдог нь тэдний өдөр тутмын хэвшил болжээ.

.....

.....

- Улс орнууд чөлөөт худалдааг дэмждэгийн шалтгааныг дараах хүснэгтэн ангилан тэмдэглэж, жишээгээр тайлбарлаарай. Хүснэгтэд нөхөх шалтгааны жишээг саарал хэсэгт харуулав.

Байгалийн хүчин зүйлс	Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс
Сэрүүн өргөрөг оршдог улсад халуун бүсэд ургадаг жимс, ногоо ургахгүй тул импортолдог	Байгалийн нөөц ихтэй ч автомашины үйлдвэр байхгүй тул машин, техникээ гадаадаас авдаг

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.5. Дэлхийн хүн амын тоо, өсөлт

Даалгаарын товч тайлбар: Улс орнуудын хүн амын төрөлт, нас баралт, ердийн өсөлт, нас хүйсийн бүтцийн эзлэх хувь зэргийг харьцуулан судласнаар хүн амын нөхөн үйлдвэрлэлийн хэв шинжийг тодорхойлох боломжтой болно.

Дараах мэдээллүүдийг уншиж, асуултад хариулаарай.

Баримт А.

Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд дэлхийн хүн ам урьд байгаагүйгээр их хүн амтай болж, өсөлт нь хадгалагдсаар байна. Улс орнуудын дунд Африк тивд орших Нигер улсын төрөлтийн түвшин 6.9 буюу хамгийн өндөр нь юм. Тус улсын төрөлтийн түвшин энэ хэвээр үргэлжилбэл (2020 онд 25.1 сая хүн амтай байсан) 2100 онд 185 сая хүрнэ гэж хүн ам зүйчид тооцоолжээ. Нигер улсын нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 7 бөгөөд хүн амынх нь дөнгөж 5% нь гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах аргыг хэрэглэдэг аж.

Эрт нөхөрт гарах, төрөх зэргээс улбаалан эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсрол доогуур, 10 охин тутмын дөрөв нь л зургаа дугаар ангид сурдаг.

Хүн амын хэт өсөлттэй холбоотой ундны усны хомсдол, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй байдал нь улам нэмэгдсээр байна.

Олон хүүхэдтэй болох нь өв залгамжлал, эд хөрөнгөө баталгаажуулах, ингэснээр бие даасан байдал, эрх мэдлийг олон нийтийн дунд олж авна гэсэн ойлголттой эцэг, эх олон ажээ.

Баримт Б.

Төрөлт буурч, дундаж наслалт нэмэгдэж буй Итали улсад хүн ам зүйн хямрал улам хүчтэй нөлөөлж байна. Итали улсын статистикийн газрын мэдээнд: 2018 онд 435 000 эх мэндэлсэн бол 2019 онд энэ тоо 5000 буурч, харин нас баралт өмнөх жилийнхээс (647 000) 14 000 орчим нэмэгдсэн. Хүн амын дундаж наслалт 2020 оны байдлаар 83.5 ба нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 1.3 байна.

Итали улсад ирэх цагаачдын тоо тогтмол өсөж, ажлын байрны сул орон зайг эзэлж байна.

Хатагтай Морандо хоёр жилийн өмнө хоёр дахь хүүхдээ тээж байхдаа Италийн хөдөлмөр эрхлэлтийн албанд түр хугацаагаар гэрээгээр ажиллаж, төрснийх нь дараа гэрээг нь сунгаагүй байна. Одоо гэр бүл нь нэг хүний цалингаар буюу (нөхрийнх) амьдардаг. Хүүхэд асрах хэрэгцээ, Италийн дотоодын эдийн засаг зогсонги байдал нь түүнийг шинэ ажил хайж олоход бэрхшээл үүсгэж байна гэж тэр үзжээ. Морандо: "Ийм эдийн засагтай нөхцөлд хүүхэдтэй болох эрсдэлтэй байдаг. Олон хосууд ийм эрсдэлд орохоос татгалздаг", "Тогтворгүй байдал бол миний найзууд хүүхэдгүй болох гол шалтгаан юм. Манай улсын эдийн засгийн байдал хүнд байгааг бүгд мэдэж байгаа" гэж хэлжээ.

1. Нигер болон Итали улсын хүн ам зүйн хоёр, хоёр асуудлыг нэрлээрэй.

Нигер улс:

Итали улс:

2. Баримтад дурдагдсан хоёр улсын төрөлтийн түвшинтэй холбоотой үүсэх сул талуудыг харьцуулж, үр дагаврыг нь жишээгээр тайлбарлаарай.

.....


Сурагчийн нэр:

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.6. Дэлхийн хүн амын нас, хүйсийн бүтэц

Даалгаарын товч тайлбар: Хүн амын нас, хүйсийн суварга ашиглан тухайн улсын хүн амын бүтэц, хөдөлмөрийн нөөц, хэтийн төлөвийг тодорхойлно. Жишээлбэл, эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувийг тооцон гаргах боломжтой.


Япон улсын хүн амын нас, хүйсийн бүтцийн 2020 ба 2040 оны хэтийн төлвийг ажиглан, дараах асуултуудад хариулаарай.



1. Япон улсын 2020 онд 0-4 насны хүн ам 30 жилийн дараа насны аль бүлэгт хамаарах вэ?
.....
.....
2. 2020 оны суваргыг ажиглан, эрэгтэйчүүдийн насны бүлэг дэх хамгийн их хувийг нэрлээрэй.
.....
.....
3. Хэтийн төлөвийг ажиглан хамгийн их хувьтай байх нас, хүйсийн бүлгийг нэрлээрэй.
.....
.....
4. Японы улсын хүн амын насны бүлгийн эзлэх хувийг хүснэгтэд нөхөж бичээрэй. Жишээг саарал хэсэгт харуулав.

Насны бүлэг	2020 он, %	2040 он (хэтийн төлөв), %
0-14	12.4	
15-64		
65-аас дээш		

5. 2020 ба 2040 оны хүн амын насны бүлгийн эзлэх хувиар тойргон диаграмм байгуулаарай.



6. Япон улсын хүн амын хөдөлмөрийн нөөц хэрхэн өөрчлөгдөхийг дүрслээрэй.
.....
.....
.....
7. Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурахад үүсэх сөрөг үр дагаврыг тодорхойлоорой.
.....
.....
.....
.....
.....
.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ____ он __ сар __ өдөр __ цаг

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.7. Дэлхийн хүн амын угсаатны бүтэц

Даалгаарын товч тайлбар: Тив, улсаараа хүн амын арьстны өнгө харилцан адилгүй байдаг. Энэ байдлыг Дэлхийн арьстны тархалтын газар зүйн зураг ашиглан илэрхийлэх боломжтой.

Сурах бичгийн хуудас 61 дэх “Зураг 3.18. Дэлхийн арьстны тархалтын зураг” – ийг ажиглан, дасгалуудыг гүйцэтгээрэй.

1. Африк тивд тархсан арьсны хэв шинжийг дүрслээрэй.

.....

2. Хойд Америкт тархсан арьстны хэв шинжийг нэрлэж, орчин үед арьстны тархалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлоорой.

.....

3. Африк тивд европ төрхийн арьсны хэв шинж тархсан шалтгааныг түүхэн үйл явцтай холбон тайлбарлаарай.

.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ____ он ____ сар ____ өдөр ____ цаг

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.7. Дэлхийн хүн амын угсаатны бүтэц

Даалгаарын товч тайлбар: Улс орнуудын хэл, шашин, соёл зэрэгт түүхэн үйл явдлууд ихээхэн нөлөөлсөн гэж судлаачид үздэг. Үүний томоохон жишээ нь: дундад зууны үеийн газар зүйн нээлтүүд юм.

Сурах бичгийн хуудас 59 дэх Зураг 3.17 ба 3.19-ийг ашиглан дараах асуултуудад хариулаарай.

1. Энэтхэг улсын албан ёсны хэлийг нэрлээрэй.
.....
.....
2. Хэлний язгуур бүлгүүд хэрхэн тархсаныг “Баримт А” болон газар зүйн их нээлттэй холбон тайлбарлаарай.

Баримт А.

XV-XX зууны дунд үе хүртэл колоничлол нь дэлхий дээр олон төрлийн нөлөө үзүүлсний нэг нь Англи, Испани, Франц зэрэг хэлний бүлгүүд давамгайлсан тогтсон явдал юм. Жишээлбэл, Их Британи нь Канад, АНУ (1776 он хүртэл), Энэтхэгийн хойг, Австрали, Африк, Карибын тэнгисийн зарим хэсгийг колоничилж байсан ба өдгөө хэл, соёл нь хадгалагдан үлджээ. Африкийн зарим улс орнууд Франц, Латин Америкийн ихэнх улсад Испани, Африкийн зарим улсад Португали хэл албан ёсны хэл нь бөгөөд Зүүн өмнөд Азийн зарим нутагт Франц, Индонезод Голланд хэлээр яригсад цөөнгүй байна.

3. Африк тив дэх шашны тархалтыг дүрсэлж, үүнтэй холбоотой хэл, соёлын онцлогийг “Баримт Б” – д тулгуурлан тайлбарлаарай.

Баримт Б.

Судлаачид “Соёл” хэмээх ойлголтын талаар маш олон янзаар тодорхойлдог. Газар зүйчид угсаатан, тэдний эдийн соёл (барилга байгууламж, сууц, хувцас, хоол идээ ундаа) болон оюуны соёл (ёс заншил, итгэл үнэмшил/шашин шүтлэг, бичиг үсэг, урлаг) зэрэг олон ялгаатай шинж байдлыг цаг хугацаа, орон зайн нөхцөлөөр нь харьцуулан судалдаг. Эдгээр нь түүхэн цаг хугацааны явцад өөрчлөгдөх ба үүнд технологийн дэвшил, үйлдвэрлэл, шилжих хөдөлгөөн, дайн, худалдаа зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байдаг. Аль цаг хугацааг авч үзэж байгаагаас хамаарч ямар хүчин зүйл нь давамгайл нөлөөлсөн болохыг тодорхойлно.

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг


ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.8. Хүн амын байршил, шилжилт

Даалгаарын товч тайлбар: Улс орнуудын хөгжлийн ялгаа нь хүн ам нэг газраас нөгөөд шилжих хүчин зүйл нь болдог.

1. Хүмүүс хотоос хөдөө рүү шилжихэд нөлөөлөх хоёр хүчин зүйлийг нэрлээрэй.
.....
.....
2. Хөдөөгөөс хот руу шилжин явахад учрах саад болох хүчин зүйлийг нэрлэж, шалтгааныг жишээ ашиглан тайлбарлаарай.
.....
.....
.....
.....
3. Африк тивийн хүн амын шилжих хөдөлгөөний графикийг ажиглан, шилжилтийн гол чиглэлийн өөрчлөлтийг дүрсэлж, шалтгааныг нийгэм, эдийн засаг, байгаль орчин зэрэгтэй холбон таамаглан тайлбарлаарай.

АФРИКААС ШИЛЖИН ЯВАГСДЫН ЗОРИН ОЧСОН ЧИГЛЭЛҮҮД (%),
2010, 2015 ОН



Дууссан: ___ сар ___ өдөр ___ цаг

Өөрийн үнэлгээ: ____

Сурагчийн нэр:



Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.9. Хот, хөдөөгийн хүн ам, хотжилт

Даалгаврын товч тайлбар: Хөгжингүй ба хөгжиж буй орнуудын хот байгуулалтын хэлбэр, хотын дахин төлөвлөлт нь харилцан адилгүй байдаг. Мөн хотын өөрийнх нь үүрэг, шинж чанараас энэ хамаарна.

1. Хот төлөвлөлтийн дараах хоёр загварын ялгааг дүрслээрэй.




Таних тэмдэг

1. Төвийн бизнес дүүрэг
2. Худалдаа, хөнгөн үйлдвэр
3. Бага орлоготой иргэдийн хороолол
4. Дунд орлоготой иргэдийн хороолол
5. Орлого өндөртэй иргэдийн хороолол
6. Аж үйлдвэрийн дүүрэг

.....

2. Дараах хүснэгтэд тулгуурлан улс орнуудын нэг хүнд ногдох ДНБ хэмжээ ба хотжилтын түвшний хоорондох хамаарлын график байгуулаарай.


Улс	Хотжилтын түвшин, (%), 2019	Нэг хүнд ногдох ДНБ (\$), 2019
Уругвай	95	16100
Аргентин	92	10000
Австрали	86	54900
Бангладеш	37	1800
Герман	77	46200
Казахстан	58	9700
Чад	23	710
Хятад	60	10200



3. Байгуулсан графиктаа тулгуурлан хотжилтын түвшин ба нэг хүнд ногдох ДНБ-ий хамаарлыг тодорхойлоорой.

.....
.....
.....

4. Өмнөх хүснэгтэн мэдээллээс улсуудын хотжилтын түвшинг дасгалын зурагт тэмдэглээрэй.



Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг


ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.9. Хот, хөдөөгийн хүн ам, хотжилт

Даалгаврын товч тайлбар: Эртний хотууд гол, нуур, тэнгисийн эрэг дагуу байгуулагдан хөгжиж ирсэн. Энэ нь ундны, ахуйн хэрэглээний усан хангамжтай холбоотойгоос гадна тээвэр, худалдаа зэрэгт чухал нөлөөтэй байсан.

1. Дэлхийн хамгийн олон хүнтэй хотуудын (2010 оны байдлаар) байршлыг газарзүйн зурагт үзүүлэв. Хотуудын газар зүйн байршлыг дүрслээрэй.

Хамгийн олон хүнтэй хот, 2010 он



.....

.....

.....

.....

2. Хотуудын байршилд нөлөөлөх байгаль, эдийн засгийн онцлогийг ангилан нэрлэж, шалтгааныг тайлбарлаарай. Саарал хэсэгт жишээг харуулав.

Байгалийн хүчин зүйлс	Эдийн засгийн хүчин зүйлс
Зарим хотууд томоохон голын эрэг дагуу байрладаг. Учир нь ундны, ахуйн хэрэгцээний усаа хангах шаардлагатай байдаг.	

Дууссан: ___ сар ___ өдөр ___ цаг

Өөрийн үнэлгээ: ____

Сурагчийн нэр:

Эхэлсэн: ___ он ___ сар ___ өдөр ___ цаг

ХҮН АМ БА СУУРЬШИЛ

11.9. Хот, хөдөөгийн хүн ам, хотжилт

Даалгаарын товч тайлбар: Хөдөөгийн суурин газруудыг эрхлэх аж ахуйн онцлогоос нь (уул уурхайн олборлох, загасчлал, мод бэлтгэлийн, тариалан эрхлэх г.м.) хамаарч ангилдаг. Энэхүү онцлог нь мөн суурин газрын хэлбэрт ч нөлөөлж байдаг.

1. Зураг А – г ажиглан хөдөөгийн зарим суурин газар шугаман бүтэцтэй байдгийн шалтгааныг тайлбарлаарай.



Зураг А.

.....

.....

.....

.....

2. Зураг А болон Б ажиглан, хөдөөгийн суурин газрын бүтэц ялгаатай байхад нөлөөлдөг байгалийн хүчин зүйлсийг ялган тодорхойлоорой.



Зураг Б.

.....
.....
.....
.....
.....

3. Хөдөөгийн суурин газрын байршилд хамгийн их нөлөөлөх нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг нэрлэж, шалтгааныг нь жишээгээр тайлбарлаж, ач холбогдлыг нь дүгнээрэй.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....